МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТАМГЫН ГАЗАР
ПАРЛАМЕНТЫН СУДАЛГАА,
ХӨГЖЛИЙН ХҮРЭЭЛЭН

“БАРААНЫ ҮНИЙН ХЭТ ХӨӨРӨГДЛИЙН ЭСРЭГ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААРХ ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА”

Судалгааны төрөл: **Харьцуулсан судалгаа**
Судалгааны код: **БГСТ-25/004**

ЗАХИАЛАГЧ: Парламентын судалгаа, хөгжлийн хүрээлэн

ГҮЙЦЭТГЭГЧ: Ж.Энхсаруул LL.M

Улаанбаатар хот
2025 он

ГАРЧИГ

1. Удиртгал
   1.1. Судалгааны арга зүй, аргачлал
   1.2. Судлагдсан байдал
   1.3. Судалгааны хүрээ, хязгаар
2. Барааны үнийг хэт хөөрөгдүүлэхийн эсрэг эрх зүйн зохицуулалтын онцлог
   2.1. Барааны үнийг хэт хөөрөгдүүлэхийг хориглох тухай ойлголт
   2.2. Барааны үнийг хөөрөгдүүлэх боломжтой этгээд
   2.3. Өрсөлдөөний эрх зүйтэй холбогдох нь
      2.3.1. Картельтай холбогдох нь
      2.3.2. Барааны үнийг зах зээлийн үнээс доогуур тогтоохтой холбогдох нь
3. Барааны үнийн хөөрөгдлийн эсрэг хязгаарлалтыг Монгол Улсын хууль тогтоомжийн хүрээнд зохицуулсан байдал
   3.1. Өрсөлдөөний тухай хуульд зохицуулсан байдал
   3.2. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд зохицуулсан байдал
   3.3. Гамшгаас хамгаалах тухай хуульд зохицуулсан байдал
   3.4. Монгол Улсын Эрүүгийн хуульд зохицуулсан байдал
4. Бусад улс орнууд дах барааны үнийн хөөрөгдлийн эсрэг хязгаарлалтын эрх зүйн зохицуулалтын талаар
   4.1. Барааны үнийн хөөрөгдлийн эсрэг Америкийн Нэгдсэн Улсын эрх зүйн зохицуулалт
      4.1.1. Үнийн өсөлтийн зөвшөөрөгдсөн дээд хэмжээг хэтрүүлэн нэмэхийг хориглох (*percentage increase cap bans*)
      4.1.2. Үнийг хэт их хэмжээгээр нэмэхийг хориглох (unconscionable price increase bans)
      4.1.3. Үнийн нэмэгдлийг бүрмөсөн хориглох (*outright ban*):
   4.2. Барааны үнийн хөөрөгдлийн эсрэг Европын Холбооны эрх зүйн зохицуулалт
   4.3. Барааны үнийн хөөрөгдлийн эсрэг Япон Улсын эрх зүйн зохицуулалт
   4.4. Барааны үнийн хөөрөгдлийн эсрэг БНСУ-ын эрх зүйн зохицуулалт
5. Дүгнэлт, санал
6. Эх сурвалж/Ном зүй

1. УДИРТГАЛ

Тодорхой улс орон, нутаг дэвсгэрийн хэмжээнд гарсан газар хөдлөлт, гал түймэр зэрэг байгалийн гамшиг болон дэлхий нийтийг бүхэлд нь хамарсан халдварт өвчин, дайн, террорист халдлага, нийтийг хамарсан эмх замбараагүй байдал гэх мэт гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй хүчин зүйлсээс үүдэн зарим төрлийн бараа бүтээгдэхүүний эрэлт өсөж, нийлүүлэлт буурах эдийн засгийн үзэгдэл гардаг. Улмаар тухайн цаг үеийн нөхцөл байдлаас хамааран эрэлт ихэссэн барааны үнэ огцом нэмэгдэх үр дагавар гардаг ба зарим тохиолдолд бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нийлүүлэлтийн бодит өртөг нэмэгдсэн эсэхээс үл хамааран цаг үеийн нөхцөл байдлыг ашиглаж ашиг олох зорилгоор барааны үнийг үндэслэлгүйгээр нэмэх явдлыг “price gouging” буюу үнийг хөөрөгдүүлэх гэж нэрлэдэг. Үүний хамгийн сүүлийн үеийн жишээ нь Ковид-19 цар тахлын үеэр цэвэрлэгээ, ариутгалын бүтээгдэхүүн болон ариун цэврийн цаас гэх мэт ахуйн хэрэглээний бүтээгдэхүүний үнэ дэлхий нийтээр өссөн явдал юм.

“Price gouging” буюу үнийг хэт хөөрөгдүүлэх үйлдэл нь тухайн бараа бүтээгдэхүүний түүхий эд, үйлдвэрлэл, хадгалалт, нийлүүлт, тээвэрлэлтийн зардлын бодитой өсөлтөөс хамааралгүйгээр, зөвхөн эрэлтийг далимдуулан ашиг олох зорилго агуулдгаараа онцлогтой. Нөгөөтэйгүүр байгалийн гамшиг, цар тахал зэрэг онцгой нөхцөл байдал үүссэн үед иргэдийн анхдагч хэрэгцээний болон тухайн нөхцөл байдалд нэн шаардлагатай бараа бүтээгдэхүүний үнийг шалтгаангүйгээр хэт өсгөж ашиг олох нь улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлөхөөс гадна иргэдийн эрх ашгийг хохироох үр дагавартай учир улс орнууд хэрэглэгчдийг хамгаалах зорилготойгоор барааны үнийн хэт хөөрөгдлийг хязгаарласан эрх зүйн зохицуулалтыг батласан байдаг.

Энэхүү судалгаа нь үнийн хэт хөөрөгдлийн эсрэг улс орнуудын зохицуулалтын онцлог, үнийг хөөрөгдүүлэх үйлдлийг хэрхэн тодорхойлж буйг тодруулах зорилготой. Судалгааны зорилго нь Америкийн Нэгдсэн Улс, Европын Холбооны орнууд болон Япон, Бүгд Найрамдах Солонгос Улсуудад хэрэгжиж буй үнийн хөөрөгдлийн эсрэг хууль тогтоомжийн талаар судлахад оршино.

1.1. Судалгааны арга зүй, аргачлал

Судалгааг эдгээр орнуудад хэрэгжиж буй үнийн хэт хөөрөгдлийн эсрэг хууль тогтоомжийн онцлогийг тогтоохоос гадна, өрсөлдөөний хууль тогтоомж болон хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хуулиудад үнийн хөөрөгдлийн эсрэг авч хэрэгжүүлж буй арга хэмжээг Европ, АНУ, Япон, Солонгос улсуудад үнийн хөөрөгдлийг хязгаарлах зорилгоор ашиглагдаж буй хууль тогтоомжийн хүрээнд харьцуулсан судалгааны аргыг ашиглан тодорхойлов.

1.2. Судлагдсан байдал

Монгол улсын хувьд Өрсөлдөөний хууль тогтоомжийн эрх зүйн зохицуулалт, Өрсөлдөөний тухай хуульд заасан өрсөлдөөнийг хязгаарлах үйл ажиллагааны төрлүүд болон хувийн эрх зүй, нийтийн эрх зүйн шинжтэй холбогдуулан хийсэн эрдэм шинжилгээний ажил,

өгүүлэл, судалгааны эх сурвалж бүтээлүүд байдаг[1] хэдий ч гэнэтийн болон давагдашгүй нөхцөл байдлын үед барааны үнийг хэт хөөрөгдүүлэхийн эсрэг зохицуулалтын талаарх эх сурвалжийн хувьд Х.Норовсүрэн “Цар тахлын үеийн өрсөлдөөний эрх зүйд аж ахуйн нэгжийн ашиг сонирхолыг хамгаалах асуудал” (2021) сэдэвт бакалаврын судалгааны ажлаас өөр шууд эх сурвалж байхгүй байна.

Мөн түүнлчэн судалгааны сэдвийн хүрээнд ерөнхий байдлаар хамаарч болохуйц сэдэв болох Өрсөлдөөний эрх зүйд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах асуудлаар хийгдсэн судалгааны эх сурвалжийн хувьд Б.Лхагважаргал “Өрсөлдөөний эрх зүй дэх хэрэглэгчийн эрхийг хамгаалах асуудал” (2021) судалгааны ажил, Л.Отгонбаярь “Өрсөлдөөний эрх зүй дэх бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, тарифын зохицуулалт” (2023) эрдэм шинжилгээний өгүүлэл зэрэг судалгааны ажлуудыг хамруулж болно.

1.3. Судалгааны хүрээ, хязгаар

Судалгааны хүрээ нь АНУ, Европын Холбооны гишүүн орнууд болон Япон, Бүгд Найрамдах Солонгос Улсыг хамруулсан ба эдгээр орнуудад хэрэгжиж буй үнийн хөөрөгдлийн эсрэг хууль, зохицуулалтаар хязгаарлагдана. Энэхүү судалгаанд бусад улс орны эрх зүйн зохицуулалт болон үнийн хөөрөгдөлтөд нөлөөлж буй хүчин зүйлсийг судлаагүй болно.

Мөн судалгааны хүрээнд зөвхөн үнийн хөөрөгдлийг хязгаарласан эрх зүйн зохицуулалтыг авч үзсэн бөгөөд эдийн засгийн хүчин зүйлсийг судлаагүй болно.

2. БАРААНЫ ҮНИЙН ХӨӨРӨГДЛИЙН ЭСРЭГ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ОНЦЛОГ

2.1. Барааны үнийг хэт хөөрөгдүүлэхийг хязгаарлах тухай ойлголт:

Price gouging буюу барааны үнийг хэт хөөрөгдүүлэх гэдгийг аливаа нутаг дэвсгэрийг хамарсан байгалийн аюулт үзэгдэл, халдварт өвчний тархалт, гамшиг, ослын онцгой, хүнд нөхцөл байдалд бараа бүтээгдэхүүний үнийг борлуулагчаас үндэслэлгүйгээр хэт нэмж ашиг олох үйлдэл[2] гэж тодорхойлж болно. Өөрөөр хэлбэл үнийг хэт хөөрөгдүүлэх үйлдлийг дараах шинжүүдээр тодорхойлж болох юм. Үүнд:

- байгалийн болон бусад давагдашгүй хүчин зүйлийн шинжтэй онцгой нөхцөл байдал үүссэн байх
- тухайн нөхцөлд байдалд зайлшгүй шаардлагатай бараа, бүтээгдэхүүн байх
- бараа бүтээгдэхүүний үнийг огцом нэмэгдүүлж тогтоосон байх
- үнийн нэмэгдэл нь үндэслэлгүй байх буюу тухайн бүтээгдэхүүний түүхий эдийн үнэ өсөх, үйлдвэрийн хүчин чадлын нэмэгдүүлсэн, барааг импортлон оруулж ирэхтэй холбоотой тээвэрлэлтийн зардал ихэссэн, дотооддоо үйлдвэрлэдэггүй бараа

[1] Судалгааны бүтээл болон шүүхийн шийдвэрийн нэгдсэн хайлтын систем (Legaldata.mn)
[2]Spencer Warkentin, Price Gouging in the Time of COVID-19: How U.S. Anti-Price Gouging Laws Fail Consumers, 36 Md. J. Int'l L. 78 (2022). p.79 Available at: https://digitalcommons.law.umaryland.edu/mjil/vol36/iss1/8

бүтээгдэхүүний хувьд үйлдвэрлэгч улсын бараа үнийн нэмэгдсэн зэрэг бодитой үндэслэл тогтоогдохгүй байх зэрэг хамаарна.

Нэг талаас хүний амьд явах эрх, иргэдийн эрүүл мэндийн асуудал нөгөө талаас энэхүү хэрэгцээг далимдуулж эрэлтэт бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгчид, бөөний болон жижиглэнгийн худалдаа эрхлэгчид барааны үнийг хэт өндрөөр тогтоож, их хэмжээний ашиг олох зүй бус түлхэц үүсдэгтэй холбогдуулан улс орнууд хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах, улсын эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах зорилгоор барааны үнийг үндэслэгүйгээр нэмэгдүүлэхийг хориглох, хязгаарлах зохицуулалтыг өөр өөрийн эрх зүйн системийн онцлогт нийцүүлэн тогтоосон байна.

Гэхдээ ийнхүү хязгаарласан, хориглосон зохицуулалт нь бараа бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, борлуулагчийн зүгээс барааны үнийг нэмэх бүрт төрийн байгууллагаас зөвшөөрөл авах, эдийн засаг, худалдааны харилцаанд төрийн хэт хяналт, зохицуулалт тогтоох утгыг илэрхийлдэггүй болохыг анхаарах нь зүйтэй. Уг зохицуулалт нь зөвхөн онцгой нөхцөл байдал үүссэн үед барааны үнийг үндэслэлгүйгээр нэмэгдүүлэх замаар хэрэглэгчийн эрх ашгийг зөрчихөөс сэргийлэх зорилгоор хязгаарлагддаг тул зохицуулалтын хүрээ, хязгаарыг зөв тодорхойлох нь чухал юм.

2.2. Барааны үнийг хөөрөгдүүлж тогтоох боломжтой этгээд

Барааны үнийг хэн хэт өндрөөр тогтоож, нэмэгдүүлж болох вэ? Бараа бүтээгдэхүүнийг түүхий эд байхаас авахуулан эцсийн бүтээгдэхүүнийг гаргаж эцсийн хэрэглэгчийн гарт хүргэх хүртэлх шат дамжлагад оролцож буй үйлдвэрлэгчид, ханган нийлүүлэгчид, жижиглэнгийн худалдаа эрхлэгчид, дистрибьюторууд, тээвэрлэгчид болоод цахим худалдааны платформуудаас гадна бараа бүтээгдэхүүний хомсдол үүссэнтэй холбоотойгоор барааг бөөнөөр худалдан авч, цааш үнэ нэмж борлуулж буй хувь хүн (шагийн худалдаачид) ч мөн үнийн хөөрөгдөл үүсгэх боломжтой. Тухайн улсын дотоодын хууль тогтоомжоор үнийн хэт хөөрөгдөл үүсгэхийг хязгаарлах зохицуулалтад хамаарах этгээдийг хэрхэн тодорхойлсноос хамааран улс орон бүрт ялгамжтай байдаг байна. (4-р хэсгээс дэлгэрүүлж уншина уу)

2.3. Өрсөлдөөний тухай хуультай холбогдох нь

Бараа бүтээгдэхүүний үнэ тогтоох асуудал нь өрсөлдөөний хуулиар хориглосон өрсөлдөөнийг хязгаарлах үйл ажиллагааны зарим хэлбэртэй төсөөтэй ойлгогддог. Өрсөлдөөний эрх зүйн үндсэн зорилго нь зах зээл дээрх чөлөөт өрсөлдөөнийг дэмжих явдал бөгөөд ийм өрсөлдөөн нь хэрэглэгчдэд хамгийн сайн бараа бүтээгдэхүүнийг боломжит доод болон зохистой үнээр хүргэх боломжийг бүрдүүлнэ[3] гэж үздэг.

Харин үнийн хэт хөөрөгдлийг хязгаарлах зохицуулалт нь хэрэглэгчдийг хамгаалах зорилгоор онцгой нөхцөл байдлын үед тодорхой бараа бүтээгдэхүүний үнийг үндэслэлгүйгээр

[3] Rubin, Janice E. *Price Gouging, the Antitrust Laws, and Vertical Integration in the Petroleum Industry: How They Are Related*. CRS Report for Congress, 2007, p.2. Vertical Integration in the Petroleum Industry: How They Are Related

нэмэгдүүлэх явдлыг хязгаарлах эсхүл хориглодог. Өөрөөр хэлбэл өрсөлдөөний эрх зүй үнийн чөлөөт өрсөлдөөнийг бий болгох, зах зээлийн зарчимд нь даатгахыг эрмэлздэг бол бараа, бүтээгдэхүүний үнийн хэт хөөрөгдлийг хязгаарлах хуулиуд үнийн хэт өсөлтөөс хэрэглэгчдийг хамгаалахын тулд төрийн зохицуулалт хийдэг ба ингэснээр өрсөлдөөний хууль тогтоомжийн зарчимтай зөрчилдөж байна[4] гэж үзэх нь ч бий.

Улс орнуудын хувьд үнийн хэт хөөрөгдлийг хязгаарлах асуудлыг бүхэлд нь өрсөлдөөний тухай хууль тогтоомжоор зохицуулах эсхүл тусгайлан хуульчлах зэргээр ялгамжтайгаар зохицуулсан талаар 4-р хэсэгт авч үзэв.

2.3.1. Картельтай холбогдох нь:

Улс орны гамшиг, ослын онцгой нөхцөл байдлын үед эрэлт ихэссэн нэр төрлийн бараа, бүтээгдэхүүний үнийг үйлдвэрлэгч, худалдаа эрхлэгчид харилцан тохиролцож хэт өндрөөр өсгөх нь картел хэлцлийн төрөлд хамаарч болох талтай.

Картел буюу өрсөлдөөнийг хязгаарлахад чиглэсэн гэрээ, хэлцэлд аж ахуй эрхлэгчид бараа бүтээгдэхүүний үнийг хэлэлцэн тогтоох, зах зээлийг нутаг дэвсгэр, үйлдвэрлэл, үйлчилгээ, борлуулалт, барааны нэр, төрөл, худалдан авагчаар хуваарилах, зах зээлд өөр этгээд орох боломжийг хязгаарлах, мэдээлэл солилцох зэрэг олон төрлийн тохиролцоог хамааруулдаг. Эдгээрээс бүтээгдэхүүний үнийг тогтоох тохиролцоогоор борлуулалтын үнийг хамгийн их буюу хамгийн бага хэмжээнд тогтоохыг зорьж, удаан хугацаандаа тухайн барааны зах зээлээс өрсөлдөгчид шахагдан гарснаар барааны үнэ эрэлтээ дагаж өсөх нь хэлцэлд оролцогчдын ашиг сонирхолд нийцдэг байна.[5]

Энэ төрлийн хэлцлийг цаг үеийн онцгой нөхцөл байдлаас үл хамааран бүх төрлийн бараа бүтээгдэхүүний зах зээлд байгуулах боломжтой бөгөөд зорилгын хувьд аж ахуй эрхлэгчид өрсөлдөөнийг хязгаарлах, бусад ижил төрлийн аж ахуй эрхлэгчдийг шахан гаргах зэрэг зорилгоор байгуулдгаараа барааны үнийг хэт хөөрөгдүүлэх үйлдлээс ялгагддаг. Гэхдээ онцгой нөхцөл байдлын үед эрэлт ихтэй бараа бүтээгдэхүүний аж ахуй эрхлэгчид хэлцэн тохирч барааны үнийг хэт өсгөх, ашиг олох зорилгоор гэрээ байгуулж болох ба үүнийг картель хэлцэлд давхар хамааруулж болох талтай.

2.3.2. Барааны үнийг зах зээлийн үнээс доогуур тогтоохтой холбогдох нь:

Бараа бүтээгдэхүүний үнийг хэт хөөрөгдүүлэхийн эсрэг зохицуулалтын нөгөө талд бараа бүтээгдэхүүнийг хэт хямд үнээр худалдаалах асуудал үүсэж болно.

Өрсөлдөөний хуулиар бараа бүтээгдэхүүний үнийг зах зээлийн дундаж үнэ, бараа, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд гарах зайлшгүй зардлаас доогуур тогтоох асуудал нь өрсөлдөөнийг хязгаарлах, бусад өрсөлдөгч аж ахуй эрхлэгчдийг зах зээлээс шахан гаргах зорилготой байдаг. Харин энэ нь барааны борлуулалтаас ашиг хонжоо олох зорилгыг шууд

[4] Мөн тэнд
[5] Phutkaradze, Paata. "Cartel Agreements." *Legal and Political Science*, vol. 1, no. 53, Jan. 2020, p. 23. [file:///C:/Users/Owner/Downloads/36-Article%20Text-57-1-10-20200330.pdf]

илэрхийлдэггүй бөгөөд гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр улс оронд онцгой нөхцөл байдал тогтоосон үед барааг зах зээлийн үнээс доогуур худалдах нь хэрэглэгчдэд эдийн засгийн хувьд аливаа хохирол учруулахгүй нь ойлгомжтой.

Энэ талаараа барааны үнийг хэт хөөрөгдүүлэх ойлголтийг эсрэг ойлголт мэт боловч барааны үнийг зах зээлийн үнэлгээнээс доогуур худалдан борлуулж өрсөлдөгчдөө зах зээлээс хавчиж гаргасны дараа барааны үнийг хэт өндрөөр тогтоох, хөөрөгдүүлэх боломжтой. Гэсэн хэдий ч нөхцөл байдал нь урт хугацаанд илрэх тул улс оронд гамшиг, ослын онцгой нөхцөл байдал тогтоосон хугацаанд хэрэглэгчдэд үнийн хөөрөгдлөөр хохирол учруулахгүй магадлал харицангуй бага.

3. БАРААНЫ ҮНИЙН ХЭТ ХӨӨРӨГДЛИЙН ЭСРЭГ ХЯЗГААРЛАЛТЫГ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ХҮРЭЭНД ЗОХИЦУУЛСАН БАЙДАЛ

Манай улсын хувьд Өрсөлдөөний тухай хууль болон Хэрэглэгчийн эрхийг хамгаалах хуулийн хүрээнд аж ахуй эрхлэгчдэд зах зээлд шударгаар өрсөлдөх үүрэг хүлээлгэх, өрсөлдөөнийг хязгаарлах үйл ажиллагааг хориглох, аж ахуй эрхлэгчийн зүгээс хэрэглэгчдэд бараа, үйлчилгээ үзүүлэхдээ хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах үүрэг хүлээх эрх зүйн зохицуулалтыг тогтоосон байдаг бөгөөд Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулиар хуулиар хүлээлгэх хариуцлагыг тодорхойлсон. Түүнлчэн Гамшгаас хамгаалах тухай хууль, Ковидын хуулиар улс оронд үүсэх онцгой нөхцөл байдлын үеийн харилцааг зохицуулахдаа барааны үнийг хэт хөөрөгдүүлэхийн эсрэг зохицуулалтыг тусгасан эсэх, зохицуулалтын үйлчлэх цар хүрээ, үйлчлэлд хамаарах этгээд болон хүлээлгэх хариуцлагын талаар авч үзье.

3.1. Өрсөлдөөний тухай хуульд зохицуулсан байдал

Өрсөлдөөний тухай хуулийн хувьд “зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгч”[6] болон “давамгай байдалтай аж ахуй эрхлэгч”[7]-дэд хориглох ноёлох үйл ажиллагаанд бараа бүтээгдэхүүний үнийг үндэслэлгүйгээр хэт өндөр тогтоохыг хамааруулсан байдаг. Тодруулбал, зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгчийн бараа бүтээгдэхүүний тоо хэмжээ, үнийн өөрчлөлтийг Монополын эсрэг газраас хянаж, бодит зардлыг нь харгалзан тухайн бараа бүтээгдэхүүнийг борлуулах зөвшөөрөл олгохоор зохицуулсан[8] байдаг бол давамгай байдлаа

[6] Зүй ёсны монополь байдалтай гэж тухайн бараа бүтээгдэхүүний зах зээлд нийлүүлэлт хийж байгаа нэг этгээд байхад л нийгмийн дундаж зардал хамгийн бага байх боломжтой зах зээлд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй эрхлэгчийг зүй ёсны монополь байдалтай гэж үзнэ. Өрсөлдөөний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэг

[7] Давамгай байдалтай аж ахуй нэгж гэж тодорхой бараа бүтээгдэхүүний зах зээлд дангаараа буюу бусад этгээдтэй хамтран, эсхүл харилцан хамаарал бүхий этгээд үйлдвэрлэл, борлуулалтын, эсхүл худалдан авалтын гуравны нэг буюу түүнээс дээш хувийг эзэлж эсхүл уг хувьд хүрээгүй ч бусад аж ахуй эрхлэгчийг зах зээлд гарч ирэх нөхцөлийг хаан боогдуулах, зах зээлээс шахан гаргах чадвартай аж ахуй эрхлэгчийг бараа бүтээгдэхүүний хүрээ, зах зээлийн газар зүйн хил хязгаар, зах зээлийн төвлөрөл, зах зээлийн хүч зэргийг үндэслэн давамгай байдалтай гэж үзэж болно. Өрсөлдөөний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 5.3 дах хэсэг

[8] Өрсөлдөөний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.7 дах хэсгүүд https://legalinfo.mn/mn/detail/12

ашиглан бараа бүтээгдэхүүнд үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоохыг давамгай байдалтай аж ахуй эрхлэгчид шууд хоригложээ[9].

Зөрчлийн тухай хуулиар дээрх зүй ёсны монополь байдалтай, давамгай байдалтай аж ахуй эрхлэгч өөрийн зүй ёсны монополь байдал, давамгай байдлаа хууль бусаар ашиглаж хуулиар хориглосон ноёлох үйл ажиллагаа явуулсан тохиолдолд учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хуулийн этгээдийг тухайн бараа бүтээгдэхүүний өмнөх жилийн борлуулалтын орлогын 4 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор[10], харин зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгч бараа бүтээгдэхүүнийхээ үнийн өөрчлөлтийг хуульд заасны дагуу Монополын эсрэг газарт мэдэгдэж зөвшөөрөл аваагүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлого, эд зүйлийг хурааж тухайн бараа бүтээгдэхүүний өмнөх жилийн борлуулалтын орлогын 3 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор[11] тус тус зохицуулжээ. Мөн түүнчлэн хуулийн аутентик тайлбарт зааснаар аж ахуй эрхлэгчийн өмнөх жилийн борлуулалтын орлогыг тооцох боломжгүй, эсхүл борлуулалт хийгдээгүй тохиолдолд тухайн аж ахуй эрхлэгчийг өөрийн хөрөнгийн 5 хувьтай тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох [12]юм.

Гэвч Өрсөлдөөний тухай хуулийн эдгээр заалтыг “price gouging” буюу онцгой нөхцөл байдлыг далимдуулан бараа бүтээгдэхүүний үнийг хөөрөгдүүлэхийн эсрэг зохицуулалтад дараах үндэслэлээр хамаарахгүй гэж үзэх боломжтой. Нэгдүгээрт, бараа бүтээгдэхүүний үнийг хөөрөгдүүлэхийн эсрэг зохицуулалт нь онцгой нөхцөл байдлын үеэр тодорхой бараа бүтээгдэхүүний эрэлт ихэссэнтэй холбоотойгоор барааны үнийг нэмэх явдлыг хориглодог бол Өрсөлдөөний тухай хуулийн дээрх зохицуулалт нь онцгой нөхцөл байдал үүссэн эсэхээс үл хамаарах байнга үйлчлэх шинжтэй. Хоёрдугаарт, “price gouging” буюу үнийн хэт хөөрөгдөлтийн эсрэг хориглолт, хязгаарлалт нь бараа бүтээгдэхүүний борлуулагч, үйлдвэрлэгч этгээдийн зах зээлд эзлэх байр сууриас үл хамааран үйлчлэх бол Өрсөлдөөний тухай хуулийн 6.1.2 болон 7.1.2 дах заалтууд нь зөвхөн зүй ёсны монополь болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчид хамаарах тул үйлчлэх хүрээний хувьд хязгаарлагдмал шинжтэй юм.

3.2. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд зохицуулсан байдал:

Ковид-19 цар тахлын үед буюу 2020 онд батлагдсан Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай (цаашид “**Ковидын хууль**” гэх) хуулиар цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах талаар цар тахлын үед өргөн хэрэглээний болон стратегийн ач холбогдол бүхий зарим бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байхад чиглэсэн төрийн зохицуулалтын арга хэмжээг Засгийн газраас авахаар, цаашлаад гамшгийн үед түрээсийн төлбөрийг нэмэх, бараа, үйлчилгээний үнийн хөөрөгдөл, зохиомол

[9] Өрсөлдөөний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2 дах хэсэг https://legalinfo.mn/mn/detail/12
[10] Зөрчлийн тухай хууль, 10.7 дугаар зүйлийн 9 дэх хэсэг https://legalinfo.mn/mn/detail/12695
[11] Зөрчлийн тухай хууль, 10.7 дугаар зүйлийн 5 дах хэсэг https://legalinfo.mn/mn/detail/12695
[12] Зөрчлийн тухай хуулийн 10.7 дугаар зүйлийн аутэнтик тайлбар https://legalinfo.mn/mn/detail/12695

хомсдол үүсгэхгүй[13] байхыг аж ахуйн нэгж, байгууллагад үүрэг болгон хуульчилсан нь “price gouging” буюу үнийн хэт хөөрөгдөлтийн эсрэг хуулийн зохицуулалт гэж үзэх боломжтой байна. Хуулийн үйлчлэлийг 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдрийг дуустал (*хууль батлагдах үед үйлчлэл 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал байсныг УИХ-аас 2022 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн Ковидын хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулиар сунгасан байдаг)* үйлчлэх хугацаатай хууль байсан тул өнөөдрийн байдлаар уг хууль эрх зүйн хувьд үйлчлэлгүй юм.

Ковидын хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэхээр заасан хэдий ч Зөрчлийн тухай хууль болон Эрүүгийн хуульд зөрчил, гэмт хэргийг шууд зааж зохицуулагдаагүйг энд тэмдэглэх нь зүйтэй.

3.3. Гамшгаас хамгаалах тухай хуульд зохицуулсан байдал

Гамшгаас хамгаалах тухай хуульд хуулийн этгээд нь өмчийн төрөл, хэлбэр үл харгалзан гамшгийн үед (гамшиг, гамшгийн онцгой нөхцөл байдал, аюулт үзэгдэл, ослын үеийн нөхцөл байдлуудыг бүхэлд хамааруулан)[14] бараа, үйлчилгээний үнийн хөөрөгдөл, зохиомол хомсдол үүсгэхгүй байх үүрэг хүлээхээр[15] зохицуулжээ.

Монгол Улсын хувьд барааны үнийг гамшиг, цар тахлын зэрэг нөхцөлд бараа, бүтээгдэхүүний хөөрөгдлийг хориглох зохицуулалтай хэдий ч юуг барааны үнийн хөөрөгдөл гэж үзэх, ямар төрлийн бараа бүтээгдэхүүнээр энэ нь хязгаарлагдах, хэр хэмжээнд бараа, бүтээгдэхүүний үнийг нэмэгдүүлэхийг хуулиар зөвшөөрөх нь тодорхойгүй байна. Цаашлаад Ковидын хуулийн заалтыг зөрчиж бараа бүтээгдэхүүний үнийн хөөрөгдөл бий болгосон гэх үндэслэлээр аж ахуй нэгжид хариуцлага хүлээлгэсэн талаар мэдээлэл нийтэд ил тод биш байна.

Зөрчлийн тухай хуулиар Гамшгаас хамгаалах тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгохоор хуульчилжээ.

3.4. Монгол Улсын Эрүүгийн хуулиар зохицуулсан байдал

Эрүүгийн хуулийн 18.1 дүгээр зүйлд Зах зээл дэх монополь, давамгай байдлаа хууль бусаар ашиглах гэмт хэргийг хуульчлахдаа “*Зах зээл дэх өрсөлдөөнийг хязгаарлах, устгах зорилгоор зүй ёсны монополь байдалтай аж ахуй эрхлэгч, давамгай байдалтай аж ахуй эрхлэгчид үгсэн хуйвалдах хэлцэл хийж зохиомлоор бараа, бүтээгдэхүүний хомсдол бий болгосон, бараа, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтыг зогсоосон, хэмжээг хязгаарласан, **бараа, бүтээгдэхүүнд үндэслэлгүйгээр хэт өндөр үнэ тогтоосон**; бусад аж ахуй эрхлэгч зах зээлд гарч ирэхэд саад учруулах, түүнийг зах зээлээс шахан гаргах*

[13] Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай (2020) хуулийн 13 дугаар зүйлийн 13.2.8 дахь заалт https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230997848051

[14] Гамшгаас хамгаалах тухай (2017) хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

[15] Гамшгаас хамгаалах тухай (2017) хуулийн 34 дүгээр зүйлийн 34.2.9 https://legalinfo.mn/mn/detail/12458

зорилгоор бараа, бүтээгдэхүүнээ бодит зардлаас доогуур үнээр зарж борлуулсан; өрсөлдөгч аж ахуйн нэгж, иргэний аж ахуйн үйл ажиллагааг зах зээлд оруулахгүй хясан боогдуулж бусдад их хэмжээний хохирол учруулсан[16] үйлдлүүдийг тус гэмт хэрэгт тооцохоор заасан байна.

Харин уг гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнийг Эрүүгийн хуульд 2020 нэмэлт, өөрчлөлт оруулахдаа "*гамшиг, аюулт үзэгдэл, халдварт өвчин, осол, аюулын үед үнийн хөөрөгдөл,* бараа бүтээгдэхүүний зохиомол хомсдолыг *бий болгосон"* үйлдлийг хамааруулахаар зохицуулсан байна.

Дээрх хуулийн зохицуулалтууд нь Монгол Улсын хувьд гамшиг, цар тахлын зэрэг онцгой нөхцөлд бараа, бүтээгдэхүүний үнийн хөөрөгдүүлэхийг хориглох талаар хуульчилсан улс гэдгийг харуулж байх хэдий ч зөвхөн аж ахуй нэгж, хуулийн этгээд цаашлаад зүй ёсны монополь болон давамгай байдалтай аж ахуй эрхлэгчид хамааралтайгаар байгаа нь бараа бүтээгдэхүүнийг хувиараа зарж борлуулдаг хувь аж ахуй эрхлэгч, иргэдэд үйлчлэхгүй байна. Мөн түүнчлэн зарим зохицуулалтыг хэрхэн ойлгож хэрэглэх талаар тодорхойгүй байгаагаас эрх зүйн зохицуулалтыг сайжруулах хэрэгцээ шаардлага байна.

4. ЗАРИМ УЛС ОРНУУД ДАХ БАРААНЫ ҮНИЙН ХЭТ ХӨӨРӨГДЛИЙН ЭСРЭГ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ТАЛААР

4.1. Барааны үнийн хэт хөөрөгдлийн эсрэг Америкийн Нэгдсэн Улсын эрх зүйн зохицуулалт

Америкийн Нэгдсэн Улсын хувьд холбооны улсын хэмжээнд үйлчлэх өрсөлдөөний болон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах гол хуулиуд[17] болох Sherman Antitrust Act (1890), Clayton Act болон Federal Trade Commission Act (1914) зэрэг хуулиуд бий боловч тэдгээрт үнийн хэт хөөрөгдлийг хориглох талаар зохицуулдаггүй байна. Харин Америкийн Нэгдсэн Улсын нийт 44 орчим муж барааны үнийн хэт хөөрөгдлийн эсрэг өөр өөрсдийн тусгайлсан хуультай[18] байна.

Эдгээр мужийн хэмжээний хуулиуд нь өөр хоорондоо хориглолтын зарчмын хувьд төсөөтэй боловч муж мужийн онцлогтой холбоотойгоор зохицуулалтын нарийвчилсан агуулга, хэлбэрийн хувьд тодорхой хэмжээнд ялгаатай зохицуулсан. Ингэхдээ state emergency буюу мужийн хэмжээнд онцгой байдал зарласан үед бараа бүтээгдэхүүн, үйлчилгээ, түрээсийн төлбөр гэх мэтийн үнийг хэт нэмэгдүүлэхийг зөвхөн байгууллага, аж ахуй эрхлэгчээс гадна хувь этгээдэд ч мөн хамааруулан хориглодог байна. Үнийн хэт хөөрөгдлийн хязгаарлалт, хориглолтыг зөрчсөнтэнй холбоотой зөрчлийн хөөн хэлэлцэх хугацааг муж бүр ялгамжтай тухайлбал зөрчил

[16] Эрүүгийн хууль (2015), 18 дугаар зүйлийн 18.1 https://legalinfo.mn/mn/detail/11634
[17] Vartan Shadarevian., Lloyd Lyall. (2024 Modern Antitrust Meets Modern Rulemaking: Evaluating the Potential of FTC Competition Rulemaking., p.415 Available at: Modern Antitrust Meets Modern Rulemaking: Evaluating the Potential of FTC Competition Rulemaking by Vartan Shadarevian, Lloyd Lyall :: SSRN
[18] Proskauer on Price Gouging, A Coast-to-Coast Reference Guide, 3, p.6-7 (2022.) Available at: https://prfirmpwwwcdn0001.azureedge.net/azstgacctpwwwct0001/uploads/7ca55e2510456bd6ce679b3b4c3abc52.pdf

гаргасан хугацаанаас хойш эсхүл зөрчлийг илрүүлснээс хойш 1-10 жилийн хооронд ялгаатайгаар хөөн хэлэлцэх хугацааг тогтоосон байдаг[19].

Барааны үнийн хэт хөөрөгдлийг хориглосон мужийн хууль тогтоомжийн зохицуулалтын агуулгыг дараах ерөнхий 3 төрөлд хуваажс[20] үзэх боломжтой байна. Үүнд:

- "*Үнийн өсөлтийн зөвшөөрөгдсөн дээд хэмжээг хэтрүүлэн нэмэхийг хориглох* (*percentage increase cap bans*)" гэж нэрлэдэг энэхүү хориглолт нь онцгой нөхцөл байдал зарласан үед бараа бүтээгдэхүүний үнийг зөвшөөрөгдсөн дээд хэмжээнээс хэтрүүлэн нэмэхийг хориглодог. Муж тус бүрийн хувьд зөвшөөрөгдсөн дээд хэмжээг харилцан адилгүй тогтоосон боловч ихэнх мужийн хувьд онцгой байдал зарлахаас өмнөх үеийн үнийг нэмэлт зардалтай шууд холбоотой өсөлтөөс гадна 10-аас дээш хувиар нэмэхийг хориглодог. Өөрөөр хэлбэл онцгой нөхцөл байдал үүссэний улмаас бодит зардал нэмэгдсэнтэй холбоотой үнийг өсөлтийг хориглоогүй ба харин бодит зардал нэмэгдсэнтэй хамааралгүйгээр 10 буюу хуульд заасан хувиас дээш хувиар үнэ нэмэхийг хориглодог. (Арканзас, Калифорниа, Мэйн, Нью Жерси, Оклахома, Орегон, Баруун Виржиниа мужууд)
- "*Үнийг хэт их хэмжээгээр нэмэхийг хориглох* (*unconscionable price increase bans*)" хязгаарлалтын хувьд ямар хэмжээгээр нэмэхийг зөвшөөрөх, ямар хэмжээг хэт их гэж үзэх тухайд маргаан дагуулдаг. Эдгээр асуудлыг тайлбарласан, нэмж зохицуулсан журамгүйгээр хэрэгжүүлэхэд төвөгтэй байдал үүсэж болох ч АНУ-ын зарим мужийн хувьд энэ зохицуулалтыг баримтлан тодорхой тохиолдлуудад торгууль ногдуулсан жишээтэй.[21] (Алабама, Флорида, Айдахо, Индиана, Айова, Массачусетс, Миссури, Нью Йорк, Хойд Каролина, Пенсильвани, Өмнөд Каролина, Теннесси, Техас, Вермонт, Виржиниа, Висконсин)
- "Үнийн нэмэгдлийг бүрмөсөн хориглох (*outright ban*)" (Коннектикут, Жоржиа, Гавай, Кентукки, Луизиана, Миссисипи, Юта)

Эдгээр хориглосон агуулга бүхий зохицуулалт тус бүрийг дор дэлгэрүүлэн авч үзэв.

4.1.1. Үнийн өсөлтийн зөвшөөрөгдсөн дээд хэмжээг хэтрүүлэн нэмэхийг хориглох (*percentage increase cap bans*)

[19] Proskauer on Price Gouging, A Coast-to-Coast Reference Guide, 3, p.6-7 (2022.) Available at: https://prfirmpwwwcdn0001.azureedge.net/azstgacctpwwwct0001/uploads/7ca55e2510456bd6ce679b3b4c3abc52.pdf

[20] Spencer Warkentin, Price Gouging in the Time of COVID-19: How U.S. Anti-Price Gouging Laws Fail Consumers, 36 Md. J. Int'l L. 84 (2022). Available at: https://digitalcommons.law.umaryland.edu/mjil/vol36/iss1/8

[21] АНУ-н Миссури муж барааг хэт өндөр үнээр борлуулахыг хориглодогтой холбогдуулан 2001 оны 9-р сарын 11-ний террорист халдлага болон 2005 оны Катрина хар салхины хямралын дараа шатахууны станцуудын гамшгийн бүс нутагт худалдаалах бараанд хэт өндөр үнэ тогтоосон гэж Missouri Attorney General-аас 48 шатахууны станцын эсрэг хэрэг үүсгэж шүүхэд шилжүүлж нийт $60,000-ийн торгууль ногдуулсан байдаг. https://www.ftc.gov/sites/default/files/documents/reports/federal-trade-commission-investigation-gasoline-price-manipulation-and-post-katrina-gasoline-price/060518publicgasolinepricesinvestigationreportfinal.pdf

Энэ төрлийн хориглолтыг анх 1993 онд Калифорниа мужид томьёолон нэвтрүүлсэн. Калифорниа мужийн Penal Code буюу Эрүүгийн хуулийн 396-р зүйлд АНУ-ын Ерөнхийлөгч эсхүл Калифорниа мужийн захирагчийн шийдвэрээр онц байдал зарласны дараа тодорхой хугацаанд түрээсийн төлбөр болон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг онц байдал зарлахаас өмнх үеийн үнээс 10-аас дээш хувиар нэмэхийг хориглодог бөгөөд энэ нь Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хамаардаг байна. Гэмт хэргийн хариуцлагын хувьд уг үнийн өсөлтөд барааны зардал өссөн нь нөлөөлсөнтэй холбоогүй бол эрүүгийн хуулиар 1 хүртэл жилээр хорих ял болон 10,000$-аас хэтрэхгүй мөнгөн торгуулийг аль нэгийг эсхүл хамтад нь ногдуулдаг[22] байна.

Мөн Аляска мужийн хувьд, Alaska Unfair Trade Practices and Consumer Protection Act-аар 2020 оны 3-р сараас хойш ковидын халдвартай холбоотой онц байдал зарлахаас өмнө бизнесийн хэвийн үйл ажиллагаанд хэрэглэгдэж байсан барааны үнийг 10 болон түүнээс дээш хувиар нэмсэн бол барааны үнийг хэт хөөрөгдүүлсэн зөрчилд тооцохоор зохицуулсан байх бөгөөд тийнхүү нэмсэн нь бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэх, худалдан авахтай шууд холбогдон үүссэн зардал буюу зах зээлийн хэвийн хэлбэлзэлтэй холбоотой бол зөрчилд хамааруулдаггүй[23] байна. Ийнхүү хууль зөрчсөн бол хууль зөрчсөн үйлдлээс бий болсон хохирлыг нөхөн төлүүлэх, зөрчил бүрт 1,000 ам.доллараас 25,000 ам.доллараас ихгүй торгууль ногдуулдаг.

4.1.2. Үнийг хэт их хэмжээгээр нэмэхийг хориглох (unconscionable price increase bans)

АНУ-ын Флорида мужийн хувьд Consumer Protection Act-аар онц байдал зарласан үед бизнес эрхлэгч, түүний төлөөлөгч, ажилтан нь өргөн хэрэглээний болон тухайн онц байдлын үед түгээмэл хэрэглэгддэг бараа бүтээгдэхүүнийг хэт өндөр үнээр худалдах, түрээслэх, эсхүл өндөр үнэ санал болгохыг хориглодог бөгөөд үнийн хэт хөөрөгдлийг бизнесийн энгийн үйл ажиллагааны үед онц байдал зарлахаас өмнө 30 хоногийн хугацаанд зарлагдсан худалдан борлуулсан болоод санал болгож байсан бараа, үйлчилгээний болоод түрээсийн төлбөр дундаж үнэтэй харьцуулах замаар тогтоодог байна. Түүнчлэн барааны үнийн өсөлтөд бараа бүтээгдэхүүнийг хадгалах, худалдаалахтай холбогдуулан гарсан нэмэлт зардалтай холбогдож байх тохиолдолд хамааруулдаггүй байна. Харин дээрх хориглолт нь бараа бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч, нийлүүлэгч бус зөвхөн эцсийн хэрэглэгчид барааг худалдаалж буй жижиглэнгийн худалдаа эрхлэгчид хамаарч, зөрчил бүрт 1,000 ам. доллараас дээш 25,000 ам.доллараас ихгүй торгууль ногдуулахаар заасан байдаг байна.[24]

Нью-Йорк мужийн хувьд Бизнесийн ерөнхий хуулийн 20-р бүлгийн 396-р зүйлийн (г) хэсэгт бараа бүтээгдэхүүнийг хэт өндөр үнээр худалдаалахыг хориглосон байдаг. Ингэхдээ олон нийтийн болон хэрэглэгчийн эрүүл мэнд, аюулгүй байдалд зайлшгүй шаардлагатай бараа

[22] California Code, Penal Code - PEN § 396 (h) https://leginfo.legislature.ca.gov/faces/codes_displaySection.xhtml?lawCode=PEN&sectionNum=396
[23] https://www.akleg.gov/basis/Bill/Text/31?Hsid=SB0241Z 2025 оны 2 сарын 6-ны өдрийн хандалтаар
[24] Regulation of trade, commerce, investments, and solicitations, Chapter 501, Sections 160 http://www.leg.state.fl.us/statutes/index.cfm?App_mode=Display_Statute&URL=0500-0599/0501/Sections/0501.160.html

бүтээгдэхүүн, үйлчилгээний зах зээлийн хэвийн бус тасалдал үүссэн тохиолдолд уг бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг хэрэглэгчдэд борлуулах шат дамжлагад оролцож буй аливаа этгээд уг бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг хэт өндөр үнээр худалдан борлуулах буюу тийнхүү худалдан борлуулахаар санал болгохыг хориглодог.[25] Бараа бүтээгдэхүүн, үйлчилгээг хэт өндөр үнээр худалдсан, санал болгосон эсэхийг шүүх тогтоох ба шүүхээс гурван хүчин зүйлийг харгалзан үздэг[26] байдаг. Үүнд, үнийн нэмэгдлийн хэмжээ хэтэрхий их байх, (ii) тухайн нөхцөлл байдалд үүссэн давуу байдлаар зүй бусаар ашигласан буюу үнэ тогтоосон арга шударга бус байх (iii) эхний хоёр хүчин зүйлийг хамтад нь агуулсан байх. Хариуцлагын хувьд нэг зөрчилд $25,000 хүртэл ам.доллар хүртэлх торгууль ногдуулах эсхүл холбогдох бараа, үйлчилгээний орлогыг хураах хариуцлага хүлээлгэдэг[27] байна.

4.1.3. Үнийн нэмэгдлийг бүрмөсөн хориглох (*outright ban*):

Жоржиа мужийн хувьд онцбайдал зарлсан тохиолдолд мужийн захирагчийн захирамжаар хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хадгалах хамгаалах, тэдний эд хөрөнгийг хамгаалахадзайлшгүй шаардлагатай гэж үзсэн бараа бүтээгдэхүүний үнийг онц байдал зарлахаас өмнөх үеийн үнээс илүү өндөр үнээр худалдахыг хориглодог. Мужийн захирагч нь энэхүү хориглолтод хамаарах бараа бүтээгдэхүүний нэрсийг тусгайлан заах шаардлагатай ба гол төлөв хоол хүнсний зүйл, шатахуун, байрны түрээс зэрэг орно. Түүнчлэн аж ахуй эрхлэгч нь байгалийн гамшгийн улмаас учирсан эд хөрөнгийн хохирлыг сэргээн засварлахад шаардлагатай бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг нэмэхийг мөн хориглодог.[28] зөвхөн жижиглэнгийн худалдааны нийлүүлэгчдэд уг зохицуулалт хамаардаг ч бөөний нийлүүлэгчдэд хамаардаггүй байна. Түүнчлэн, Хариуцлагын хувьд $2000-15,000 хүртэлх мөнгөн торгууль ногдуулдаг[29] байна.

Муж бүрийн үнийн хөөрөгдлийн эсрэг хуулийн хэрэгжилтийн хүрээнд Ковид-19 цар тахлын үед үнийн хэт хөөрөгдөл үүсгэсэн зөрчил гаргасан аж ахуй эрхлэгч компаниудад торгууль ногдуулсан талаарх мэдээллүүд уг хуульд хяналт тавих эрх бүхий байгууллагуудын албан ёсны мэдээллийн сайтад тавигдсан байна. Жишээ болгон дурдвал, Northwest-Lux, Mobile Rush болоод EMC Group зэрэг компаниуд нь Amazon дээр 2020 оны 2-3 сарын хооронд PURELL® гар ариутгагчийг хэт өндөр үнээр борлуулсан нь тогтоогдсон тул Нью-Йорк мужийн Прокурорын газ-аас тэдгээр компаниудад торгууль ногдуулж, нөхөн төлбөр олгохоор шийдвэрлэсэн байна.[30]

Тухайлбал, 2020 оны 3-р сарын 1-ээс 3-р сарын 6-ны хооронд Northwest-Lux компани Amazon дээр PURELL® гар ариутгагчийг хэт өндөр үнээр борлуулсан байна. Тухайлбал, 2 литрийн PURELL®-ийн үнэ $79.99-$129.99 байхад, ердийн үнэ нь $20.87-$35.00, 20 ounce савлагаатай 2

[25] N.Y. General Business Law (GBS), Chap 20, Sec § 396-r https://www.nysenate.gov/legislation/laws/GBS/396-R
[26] Мөн тэнд
[27] Мөн тэнд
[28] *O.C.G.A.* Sections. § 10-1-393.4 (2008) https://consumer.georgia.gov/business-services/emergency-price-
[29] *O.C.G.A.* Sections. § 10-1-438 https://consumer.georgia.gov/business-services/emergency-price-controls#:~:text=Sections%2010%2D1%2D393.4%20and,of%20persons%20or%20their%20property
[30] https://ag.ny.gov/press-release/2020/attorney-general-james-stops-three-amazon-sellers-price-gouging-hand-sanitizer 2025 оны 2 сарын 5-ны өдрийн хандалтаар

багц нь $69.99 байхад ердийн үнэ нь $14.88-$35.10 байжээ. Иймд Northwest-Lux компани $20,000 торгууль болон худалдан авсан хэрэглэгчдэд $5,717.13 нөхөн төлбөр төлөхөөр шийдвэрлэсэн байна.

4.2. Барааны үнийн хэт хөөрөгдлийн эсрэг Европын Холбооны эрх зүйн зохицуулалт:

Европын Холбооны хувьд Anti-price gouging буюу үнийн хэт хөөрөгдлийн асуудлыг Америкийн Нэгдсэн Улс шиг тусгайлан авч үзэж, түүний эсрэг зохицуулалтыг хууль, тогтоомжоор шууд нэрлэж зохицуулаагүй ч гишүүн улс хоорондын Treaty on the Functioning of the European Union (TFEU) буюу Европын Холбооны Хамтын ажиллагааны гэрээний 102 дугаар зүйлд аж ахуй эрхлэгчдэд хориглосон үйл ажиллагааны хязгаарлалтууд дунд үнийн хөөрөгдлийн эсрэг зохицуулалтыг агуулсан гэж авч үздэг[31] байна.

Өрсөлдөөний хуулийн хязгаарлалтын хүрээнд European Commission (EU) болон Үндэсний өрсөлдөөний газар (National Competition Authorities) аль аль нь Европын холбооны хүрээнд уг зөрчлийг шалгах, хариуцлага тооцох эрхтэй[32] байдаг байна.

TFEU-н 102 дугаар зүйлд дотоодын зах зээлд эсхүл зэх зээлийн томоохон хэсэгт доминант буюу ноёлох байр суурьтай этгээдэд дотоодын зах зээлээс холбооны улс хоорондын худалдаанд нөлөөлөхүйц өрсөлдөөний эсрэг дараах үйл ажиллагааг явуулахыг хориглодог. [33] Үүнд:

- <u>шударга бус борлуулалтын үнэ</u> эсхүл бусад шударга бус худалдааны нөхцөлийг шууд эсвэл шууд бусаар тогтоох;
- үйлдвэрлэл, зах зээл эсвэл техникийг хэрэглэгчдэд хохирол учруулах замаар хязгаарлах;
- ижил төстэй гүйлгээг бусад худалдааны талуудтай харьцуулахад өөр өөр нөхцөлүүдийг хэрэглэж, тэднийг өрсөлдөх чадварын хувьд сулруулах;
- гэрээний зорилготой холбоогүй нэмэлт үүргийг гэрээний оролцогч талд хүлээх; зэрэг

Шударга бус үнийг тогтоох гэдэгт нь үнийн хэт хөөрөгдлийг хязгаарласан агуулга хамаарах боломжтой хэдий ч тус хориглолтоор барааны үнийг хөөрөгдүүлсэн этгээдэд хариуцлага хүлээлгэхийн тулд тухайн этгээд нь зөвхөн доминант байдалтай этгээд буу тодорхой барааны зах зээлийн 40%-иас дээш хувийг эзэмшдэг этгээд байх ёстой байна. Харин хэрэглэгчдээс хамааран түр зуур доминант байдалтай байгаа (Transitory market power) этгээдийг оруулах хандлагаас тэдгээрийн үйл ажиллагааг мөн 102 дугаар зүйлийн хэрэгжилтэд хамааруулах боломжтой[34] болсон байна.

---

[31] N. Njegovan, B. Ristić,. The Anatomy of Price Gouging: a Regulatory of Competition Law Antidote., p.396 https://www.researchgate.net/profile/Bojan-Ristic/publication/361596281_The_Anatomy_of_Price_Gouging_A_Regulatory_or_Competition_Law_Antidote/links/64eb0ff640289f7a0fbc28e5/The-Anatomy-of-Price-Gouging-A-Regulatory-or-Competition-Law-Antidote.pdf

[32] Spencer Warkentin, Price Gouging in the Time of COVID-19: How U.S. Anti-Price Gouging Laws Fail Consumers, 36 Md. J. Int'l L. 88 (2022). Available at: https://digitalcommons.law.umaryland.edu/mjil/vol36/iss1/8

[33] Article 102 of Treaty on the Functioning of the European Union (TFEU) available at: https://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=CELEX:12012E/TXT:en:PDF

[34] Spencer Warkentin, Price Gouging in the Time of COVID-19: How U.S. Anti-Price Gouging Laws Fail Consumers, 36 Md. J. Int'l L. 89 (2022). Available at: https://digitalcommons.law.umaryland.edu/mjil/vol36/iss1/8

Мөн Барааны үнэ хэт өндөр байгааг тогтоохын тулд Европын шүүх(European Court of Justice)-ийн практикт барааны үнийг үндэслэлгүйгээр хэт өндөр байгаа эсэхийг барааны үндсэн үнэ (actual price)-г барааны зардал (actual cost)-тай харьцуулах замаар тодохойлдог[35] байна.

Гэсэн хэдий ч ковид-19-ийн улмаас Европ даяар бүтээгдэхүүнүүдийн эрэлт ихсэж, зах зээлийн үнэ энгийн үеэс илүү өндөр байгаа учир зах зээлд давамгай байр суурьтай компаниудын үнийг өөр газарзүгийн бүсэд байрлах бусад компаниудын үнийн түвшинтэй харьцуулах нь цар тахлын үед тохиромжгүй гэж үзэх хандлага ч мөн түгээмэл байсан тул үнийн хэт хөөрөгдлийг зохицуулахад Европын холбооны хувьд хүндрэл үүсдэг[36] байна.

4.3. Барааны үнийн хэт хөөрөгдлийн эсрэг Япон Улсын эрх зүйн зохицуулалт:

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Япон Улсын Өрсөлдөөний хууль нь анх 1947 онд “私的独占の禁止及び公正取引の確保に関する法律（昭和二十二年法律第五十四号[37]” буюу “Хувийн Монополийг Хориглох, Шударга Худалдааг Дэмжих тухай хууль” (цаашид “Япон Улсын Өрсөлдөөний хууль” гэх) нэртэйгээр батлагдаж, хэрэгжиж эхэлсэн. Япон Улсын Өрсөлдөөний хууль нь Америкийн Нэгдсэн Улсын “Sherman Antitrust Act” хуулиас сэдэвлэж, агуулгын хувьд АНУ-ын хууль, бодлогын зарчмуудыг ихээр тусгасан байдаг бөгөөд Япон Улсын онцлогт тохируулан зарим өөрчлөлтүүдийг хийсэн байдаг.

Япон Улсын Өрсөлдөөний эрх зүйн хууль, тогтоомжид барааны үнийг хэт өндрөөр тогтоох “price gouging” хэмээх ойлголт нь 便乗値上げ (бинжо нэагэ) тодорхой нөхцөл байдал (жишээ нь, гамшиг, хангамжийн хомсдол) дээр дөрөөлөн үнийг хэт өсгөх, мөн түүнчлэн шударга бус, үндэслэлгүй үнийн өсөлт хэмээх 不当な値上げ (хүтона нэагэ) гэх нэр томьёогоор илэрхийлэгдэн туссан байна.

Япон Улсын Өрсөлдөөний хуулийн 2 дугаар зүйлд[38] 不当な値上げ (хүтона нэагэ) буюу бараа, бүтээгдэхүүний үнийг үндэслэлгүйгээр өсгөх үйл ажиллагааг шударга өрсөлдөөнд саад учруулахуйц үйлдэл хэмээн дараах байдлаар тодорхойлсон байдаг:

“Article 2.9 ... any act falling under any of the following items, which is likely to impede fair competition and which is designated by the Japan Fair Trade Commission, other than the acts listed in the preceding items:

(vi) engaging in transactions at an unjust price; ...”

Харин 便乗値上げ (бинжо нэагэ) буюу байгалийн гамшиг, цар тахал зэрэг онцгой нөхцөл байдлын үед барааны үнийг хэт өсгөхийн эсрэг эрх зүйн зохицуулалтын хувьд Япон Улс нь өмнөх хэсэгт дурьдсан Америкийн Нэгдсэн Улс болон Европын Холбооны адилаар хууль, эрх зүйн актаар зохицуулахын зэрэгцээ тухайн тохиолдол бүрт зориулан арга хэмжээг авч, зохих журмаар зохицуулж ирсэн байна.

---

[35] Мөн тэнд
[36] Exploitative Pricing in the Time of Coronavirus—The Response of EU Competition Law and the Prospect of Price Regulation – PM https://pmc.ncbi.nlm.nih.gov/articles/PMC7454713/#sec9
[37] Хувийн Монополийг Хориглох, Шударга Худалдааг Дэмжих тухай хууль
https://laws.e-gov.go.jp/law/322AC0000000054#MainProvision
Хуулийн албан ёсны орчуулга https://www.japaneselawtranslation.go.jp/en/laws/view/4767
[38] Хувийн Монополийг Хориглох, Шударга Худалдааг Дэмжих тухай хууль
https://laws.e-gov.go.jp/law/322AC0000000054#MainProvision

Тухайлбал, 1973 онд Үндэстний амьдралыг тогтворжуулах яаралтай арга хэмжээний тухай хуулийг (国民生活安定緊急措置法) баталсан бөгөөд тус хуулиар үнийн огцом өсөлт болон бусад нөхцөл байдлыг зохицуулдаг[39].

26 дугаар зүйлийн 1 дэх хэсэг: "Хуульд өөрөөр заагаагүй бол, үнэ мэдэгдэхүйц өссөн эсхүл өсөх эрсдэлтэй байгаа үед хэрэгцээт бараа бүтээгдэхүүн нь хомсдолд орж, эрэлт нийлүүлэлтийг тэнцвэржүүлэхэд хүндрэлтэй бөгөөд иргэдийн амьдралын тогтвортой байдал эсхүл үндэсний эдийн засгийн хэвийн үйл ажиллагаанд ноцтой саад тотгор учруулж эсхүл учруулж болзошгүй гэж хүлээн зөвшөөрөгдсөн тохиолдолд тухайн хэрэгцээт бараа бүтээгдэхүүн гэдгийг засгийн газрын тогтоолоор тодорхойлж, тэдгээр бараа бүтээгдэхүүний хуваарилалт, түгээлт, ашиглалт, дамжуулалт зэргийг хязгаарлах эсхүл хориглох талаар холбогдох зохицуулалтыг хийж болно."

Мөн түүнчлэн, Япон Улсын Засгийн газраас 2022 онд COVID-19 цар тахлын үеийн "Түүхий нефтийн үнэ, бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт зэрэгт чиглэсэн цогц шуурхай арга хэмжээ[40]"-ний хүрээнд баталсан бодлогын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлсэн. Үүнд:

- **Шатахууны үнийн өсөлтийг хязгаарлах**: Түүхий нефтийн үнийн өсөлтөөс үүдэлтэй шатахууны жижиглэнгийн үнийн өсөлтийг бууруулахын тулд нефть импортлогчдод үнийн дэмжлэг үзүүлэх,
- **Үндсэн хүнсний бүтээгдэхүүний тогтвортой хангамж**: Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн өртгийг бууруулах арга хэмжээнүүд авч, тээврийн хангамжийг дэмжих,
- **Үйлдвэрлэлийн салбарын түүхий эдийн тогтвортой байдал**: Хагас дамжуулагч, метал зэрэг стратегийн түүхий эдийн нийлүүлэлтийг тогтвортой байлгах зэрэг үнийн өсөлт, хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлт, жижиг дунд бизнесийн дэмжлэг зэрэг олон чиглэлд арга хэмжээ авч хэрэгжүүлсэн байна.

Эдгээр арга хэмжээ нь худалдаа эрхлэгчдэд цар тахлаар далимдуулан бараа, бүтээгдэхүүний үнийг нэмэхгүй байх үүрэг, хязгаарлалт тогтоосон шууд тогтоосон шинжтэй биш, харин тэдний үйл ажиллагааг дэмжих замаар үндэслэлгүйгээр үнэ нэмэх явдлаас шууд бусаар сэргийлсэн зохицуулалт болжээ.

Мөн түүнчлэн, Япон Улсын Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах газраас[41] үнийн хэт хөөрөгдлийг мэдээллэх иргэдэд "нээлттэй цонх" ажиллуулж, үнийн хэт хөөрөгдлийг шийдвэрлэж эхэлсэн байна. Мөн Хэрэглэгчийн төлөө газрын цахим хуудас руу орж үзэхэд тухайн мэдээллэсэн үнийн хэт хөөрөгдлийн бодит хэргүүдийн шийдвэрийн цахим санг ч мөн үүсгэж олон нийтэд хүртээмжтэй байдлаар байршуулжээ[42]. Жишээлбэл, 2020 оны 7 дугаар сараас эхлэн 22 настай эрэгтэй Х нь Япон улсын Кообэ хотод 100 иенийн дэлгүүр болон бусад дэлгүүрүүдээс амны хаалтыг их хэмжээгээр худалдан авч, уух зүйлтэй нь хамтад нь 5000 иенээр буюу өндөр үнээр зарж борлуулж байсан байна. Энэхүү хэргийг Үндэстний амьдралыг тогтворжуулах яаралтай арга хэмжээний тухай хуулийг зөрчсөн гэж үзэж 200,000 иенээр торгох арга хэмжээ авсан байна.

[39]Act on Emergency Measures for Stabilizing Living Conditions of the Public (Act No. 121 of December 22, 1973) https://laws.e-gov.go.jp/law/348AC0000000121

[40] Comprehensive emergency measures to address soaring crude oil and commodity prices, 2022 https://www5.cao.go.jp/keizai1/keizaitaisaku/2022/20220426_taisaku_gaiyo.pdf

[41] Consumer Affairs Agency, Government of Japan https://www.caa.go.jp/policies/policy/consumer_partnerships/price_measures/price_gouge

[42] Consumer Life Accident Information https://www.jikojoho.caa.go.jp/ai-national/

Япон Улсын хувьд гэнэтийн болон давагдашгүй хүчний шинжтэй нөхцөл байдалд барааны үнийг тогтворжуулах тусгай хуультай бөгөөд шаардлагатай тохиолдолд бараа бүтээгдэхүүний үнийн өсөлт зэрэгт чиглэсэн цогц шуурхай арга хэмжээг авдаг байна.

4.4. Барааны үнийн хэт хөөрөгдлийн эсрэг Бүгд Найрамдах Солонгос Улсын эрх зүйн зохицуулалт:

Бүгд Найрамдах Солонгос Улс (БНСУ) нь үнийн хэт хөөрөгдлийн эсрэг бие даасан хуультай. 1999 онд батлагдсан “Үнийн тогтворжуулалтын тухай[43]” хууль нь дараах зорилготой ба уг хуулийн хүрээнд Засгийн газар, зохицуулагч байгууллагууд эдийн засгийн орчныг тогтворжуулах, мөн зарим бүтээгдэхүүний үнэ хэт өсөхөөс сэргийлэх чиглэлд арга хэмжээ авч эхэлсэн. Үүнд:

1. **Шударга өрсөлдөөн**: Зах зээлийн үйл ажиллагааг зөрчсөн, зах зээлийн эрх мэдлийг гажуудуулсан үйлдлүүдийг хязгаарлах.
2. **Хэрэглэгчийг хамгаалах**: Хэрэглэгчдийг шударга бус үнийн өсөлтөөс хамгаалахад чиглэсэн арга хэмжээ авах.
3. **Гамшиг болон бусад онцгой нөхцөлд үнийн өсөлтөөс сэргийлэх**: Байгалийн гамшиг, эдийн засгийн хямрал зэрэг тохиолдолд зохицуулалт хийх.

Дээрх хуультай уялдан Үнийн тогтворжуулалтын тухай хуулийн хэрэгжилтийн акт[44] батлагдаж, хамгийн сүүлд 2023 онд шинэчлэгджээ. Уг актад зааснаар дараах тохиолдолд үнийн дээд хязгаарыг төрөөс тогтоох боломжтой. Үүнд:

- Олон улсын зах зээлд түүхий эдийн үнэ огцом өсөх, валютын ханшийн өөрчлөлт зэрэг санхүү, эдийн засгийн хямралаас үүдэн олон нийтэд нэн шаардлагатай зарим бараа, үйлчилгээний нийлүүлэлтэд томоохон саад учрах, үнийн огцом өсөлт гарсан;
- Байгалийн гамшиг, газар хөдлөлт, гадаад, дотоод хямрал, түүнтэй адилтгах бусад нөхцөл байдлын улмаас олон нийтэд нэн шаардлагатай зарим бараа, үйлчилгээний нийлүүлэлт их хэмжээгээр тасарсан, үнэ огцом өссөн;

  Эрэлт, нийлүүлэлтийн гэнэтийн өөрчлөлтөд орсон бараа бүтээгдэхүүнийг хэрэглэж буй ард иргэдийн амьдралд тогтвортой байдлыг хангах, эсхүл тухайн барааг үйлдвэрлэж буй аж үйлдвэрийн бүтцийн оновчтой өөрчлөлтийг хангах шаардлагатай болсон.

Харин уг актын 13 дугаар зүйлд онцгой нөхцөл байдлын үеийн буюу нэгдүгээрт, эдийн засгийн хямрал, түүхий эдийн үнийн өсөлт, валютын ханшийн өөрчлөлт зэрэг шалтгааны улмаас зарим бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн хомсдол эсвэл үнийн өсөлт үүссэн үед, хоёрдугаарт, дотоод эсвэл гадаад хямрал, байгалийн гамшиг, газар хөдлөлт зэрэг шалтгааны улмаас үнийн өсөлт эсвэл нийлүүлэлтийн хомсдол үүссэн тохиолдолд төрөөс уг актыг хэрэгжүүлэх тухай заажээ.

[43] Price stabilization act, Korea (1999) https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=2967
[44] Enforcement Decree Of The Price Stabilization Act
https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=66984&type=part&key=19

5. ДҮГНЭЛТ, САНАЛ

Гамшиг, ослын онцгой нөхцөл байдлын үед барааны үнийн хэт хөөрөгдлийг хориглохэрх зүйн зохицуулалт нь хэрэглэгчдийг хамгаалах болон эдийн засгийн сөрөг нөлөөллийг бууруулахад чиглэсэн чухал арга юм. Энэ хүрээнд АНУ, Европын Холбоо, Япон болон БНСУ-ын хууль тогтоомжид хэрхэн зохицуулсан болохыг харьцуулан авч үзэхэд үнийн хэт хөөрөгдөлтэй тэмцэхэд улс орон бүр ялгаатай хандлага баримталж байна.

Монгол Улсын хувьд гамшгийн үед болон Ковид-19 цар тахлын нөхцөлд бараа, бүтээгдэхүүний хөөрөгдлийг хязгаарлах зохицуулалтын талаар холбогдох хуулиудад зохицуулж хуульчилсан байх ч юуг барааны үнийн хөөрөгдөл гэж ойлгох, хэрхэн хөөрөгдүүлсэн гэж үзэх болоод ямар төрлийн бараа бүтээгдэхүүнээр энэ нь хязгаарлагдах талаар тодорхой зохицуулалт байхгүйгээс гадна үнийн хөөрөгдөл үүсгэхийг хязгаарлахдаа аж ахуй нэгж, хуулийн этгээдэд л зөвхөн хамааралтайгаар зохицуулсан байгаагаас онцгой нөхцөлд бараа бүтээгдэхүүний үнийг хөөрөгдөл үүсгэх боломжтой жижиглэнгийн худалдаа эрхэлдэг аж ахуй эрхлэгч, иргэдэд хамаарахгүй байна.

АНУ-д барааны үнийн хөөрөгдлийн эсрэг зохицуулалтыг мужийн хууль тогтоомжийн хүрээнд 3 өөр хэлбэрээр тодорхойлсон ба зарим тохиролдолд эрүүгийн хуулиар гэмт хэрэг болгон хуульчилснаас гадна ихэнх тохиолдод торгууль ногдуулах, хэрэглэгчдэд нөхөн төлбөр олгох байдлаар шийдвэрлэж байна. Муж бүрийн хуулиар үнийн хэт хөөрөгдөл үүсгэх хориглолтод хамаарах этгээдийг өргөн болон нарийвчилсан хүрээгээр ялгамжтай зохицуулсан ба зарим мужийн хувьд жижиглэнгийн худалдаа эрхлэгчдийг үнийн хөөрөгдөл бий болгохыг хязгаарласан шинжтэй ч үйлдвэрлэгч, нийлүүлэгчдийн хувьд хэрхэх нь тодорхойгүй байна.

Европын Холбооны хувьд, Европын холбооны үйл ажиллагааны гэрээгээр үнийн хэт хөөрөгдөл үүсгэх буюу “price gouging” гэа ойлголтыг шууд хуульчлаагүй байх ч шударга бус борлуулалтын үнийг шууд эсвэл шууд бусаар тогтоохыг өрсөлдөөнийг хязгаарлах үйл ажиллагаанд хамааруулж хуульчилсан. Гэвч шударга бус үнийг тогтоосон гэдгийг тогтоох болоод хууль зөрчсөн зөрчилд жижиг бизнес эрхлэгчид уг зохицуулалт үйлчлэхгүй зэрэг асуудлууд үүсдэг байна.

Япон Улсын хувьд уг асуудлыг тусгайлан зохицуулсан Үндэстний амьдралыг тогтворжуулах яаралтай арга хэмжээний тухай хуультай бөгөөд уг хуулиар “price gouging” хэмээх ойлголтыг тодорхойлж, онцгой нөхцөл байдал үүсэх бүрт нөхцөл байдалд тохируулан бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөд зэрэгт чиглэсэн цогц шуурхай арга хэмжээг тохируулан авдаг байна.

Бүгд Найрамдах Солонгос Улсын хувьд эдийн засгийн хямрал, түүхий эдийн үнэ өсөлт, валютын ханшийн өөрчлөлт зэрэг шалтгааны улмаас болон дотоод эсвэл гадаад хямрал, байгалийн гамшиг, газар хөдлөлт зэрэг шалтгааны улмаас үнийн өсөлт эсвэл нийлүүлэлтийн хомсдол үүссэн тохиолдолд төрөөс үнэ тогтворжуулах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байна.

Ингэснээр аж ахуй эрхлэгчид дур мэдэн үнийн хэт хөөрөгдөл үүсгэх боломжийг хязгаарласан гэж үзэж болно.

Нэгтгэн дүгнэвэл, улс орон бүр бараа бүтээгдэхүүний үнийн хэт хөөрөгдлийг хязгаарлах, хориглох арга хэмжээг харилцан адилгүй хэлбэр, агуулгаар тогтоосон ба уг хориглолт, хязгаарлалт үйлчлэх онцгой нөхцөл байдал гэдэгт юуг ойлгохыг тодорхойлсон байдаг байна. Зарим улсад Өрсөлдөөний хуульд ерөнхий агуулгаар үнийн хэт хөөрөгдлийг хязгаарласан байхад нөгөө талаас хэт хөөрөгдөлдлийг хэрхэн тодорхойлохыг нарийвчлан зохицуулжээ. Манай улсад барааны үнийн хэт хөөрөгдлийг хязгааралах асуудлыг хуульчилсан байгаа нь сайшаалтай боловч хууль хэрэгжилтийн үе шатанд хуулийн зөрчлийг тодорхойлоход бусад улстай харьцуулахад хэт ерөнхий зохицуулсан тул хүндрэл үүсэхээр байна.

Барааны үнийн хэт хөөрөгдлийг хязгаарлах, хориглох зохицуулалтыг улс орнууд ихэнх тохиолдолд цаг үеийн шинжтэйгээр аливаа хуульчлах зохицуулах, өмнөх хуулийг шинэчлэн батлах, эсхүл тухайн нөхцөлд авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар шийдвэрийг гаргадаг байх тул эрх зүйн зохицуулалтыг бий болгохоос гадна аж ахуй эрхлэгчид болон хэрэглэгчдэд хуулийн зохицуулалтыг таниулах нь бараа бүтээгдэхүүний үнийн хөөрөгдлийг хязгаарлах хууль тогтоомжийг үр дүнтэй хэрэгжүүлэх, ийм төрлийн хуулийн зөрчлөөс урьлчилсан сэргийлэхэд чухал ач холбогдолтой юм.

Мөн барааны үнийг хэт хөөрөгдүүлэхийн эсрэг хууль тогтоомжийн үр нөлөөг дээшлүүлэхийн тулд хэн уг хязгаарлалтад хамаарахыг тодорхой зохицуулах нь зүйтэй. Энэхүү судалгааны хүрээнд эрх зүйн зохицуулалтыг харьцуулсан улс орнуудаас зарим улсын хуулиар томоохон бараа бүтээгдэхүүний үйлдвэрлэгч, нийлүүлэгч зэрэг компаниудад чиглэсэн хязгаарлалтын зохицуулалттай байхад, нөгөө талаас зөвхөн жижиглэнгийн худалдаа эрхлэгчдэд чиглэсэн байдлаар ялгамжтай зохицуулж байна. Энэ нь үнийн хөөрөгдлийн хуулийн хязгаарлалтад хамаарахгүй боловч хэт хөөрөгдөл бий болгоход нөлөө ихтэй аж ахуй эрхлэгчдэд хариуцлага хүлээлгэх боломжгүй нөхцөлийг үүсгэж болно. Мөн түүнчлэн хуулийн гол зорилго болох хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалах зорилгыг бүрэн хангаж чадахгүйд ч хүрэх боломжтойг анхаарч улс орны эдийн засгийн онцлогийг харгалзаж үнийн хэт хөөрөгдлийн эсрэг зохицуулалтыг хэнд хамааруулахыг шийдвэрлэх шаардлагатай юм.

6. НОМ ЗҮЙ, ЭХ СУРВАЛЖ

Хууль, эрх зүйн акт:

1. Өрсөлдөөний тухай хууль (2010) https://legalinfo.mn/mn/detail/12
2. Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль (2020) https://legalinfo.mn/mn/detail?lawId=16230997848051
3. Зөрчлийн тухай хууль (2017) https://legalinfo.mn/mn/detail/12695
4. Эрүүгийн хууль (2015) https://legalinfo.mn/mn/detail/11634
5. New york, General Business Law (GBS) https://www.nysenate.gov/legislation/laws/GBS/396-R
6. Georgia Consumer Protecton Act (1975) https://consumer.georgia.gov/business-services/emergency-price-controls#:~:text=Sections%2010%2D1%2D393.4%20and,of%20persons%20or%20their%20property
7. California Code, Penal Code https://leginfo.legislature.ca.gov/faces/codes_displaySection.xhtml?lawCode=PEN&sectionNum=396
8. Florida, Regulation of trade, commerce, investments, and solicitations (2024) http://www.leg.state.fl.us/statutes/index.cfm?App_mode=Display_Statute&URL=0500-0599/0501/Sections/0501.160.html
9. Treaty on the Functioning of the European Union (TFEU) available at: https://eur-lex.europa.eu/LexUriServ/LexUriServ.do?uri=CELEX:12012E/TXT:en:PDF
10. Хувийн Монополийг Хориглох, Шударга Худалдааг Дэмжих тухай хууль https://laws.e-gov.go.jp/law/322AC0000000054#MainProvision
11. Comprehensive emergency measures to address soaring crude oil and commodity prices, 2022 https://www5.cao.go.jp/keizai1/keizaitaisaku/2022/20220426_taisaku_gaiyo.pdf
12. Consumer Affairs Agency, Government of Japan https://www.caa.go.jp/policies/policy/consumer_partnerships/price_measures/price_gouge
13. Consumer Life Accident Information https://www.jikojoho.caa.go.jp/ai-national/
14. Price stabilization act, Korea (1999) https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?lang=ENG&hseq=2967
15. Enforcement Decree Of The Price Stabilization Act https://elaw.klri.re.kr/eng_mobile/viewer.do?hseq=66984&type=part&key=19

Цахим эх сурвалж:

1. Spencer Warkentin, Price Gouging in the Time of COVID-19: How U.S. Anti-Price Gouging Laws Fail Consumers, 36 Md. J. Int'l L. (2022). Available at: https://digitalcommons.law.umaryland.edu/mjil/vol36/iss1/8

2. Rubin, Janice E. *Price Gouging, the Antitrust Laws, and Vertical Integration in the Petroleum Industry: How They Are Related*. CRS Report for Congress, 2007 Vertical Integration in the Petroleum Industry: How They Are Related
3. Vartan Shadarevian., Lloyd Lyall. (2024 Modern Antitrust Meets Modern Rulemaking: Evaluating the Potential of FTC Competition Rulemaking., p.415 Available at: Modern Antitrust Meets Modern Rulemaking: Evaluating the Potential of FTC Competition Rulemaking by Vartan Shadarevian, Lloyd Lyall :: SSRN
4. Phutkaradze, Paata. "Cartel Agreements." *Legal and Political Science*, vol. 1, no. 53, Jan. 2020, [file:///C:/Users/Owner/Downloads/36-Article%20Text-57-1-10-20200330.pdf]
5. Kaitlin A. Caruso. *Price Gouging, the Pandemic, and What Comes Next*. (2023) Available at: https://digitalcommons.mainelaw.maine.edu/cgi/viewcontent.cgi?article=1157&context=faculty-publications
6. Federal Trade Commision. *Investigation of Gasoline price Manipulation and Post-Katrina Gasoline Price Increases.* (2006) https://www.ftc.gov/sites/default/files/documents/reports/federal-trade-commission-investigation-gasoline-price-manipulation-and-post-katrina-gasoline-price/060518publicgasolinepricesinvestigationreportfinal.pdf
7. N. Njegovan, B. Ristić,. The Anatomy of Price Gouging: a Regulatory of Competition Law Antidote., p.396 https://www.researchgate.net/profile/Bojan-Ristic/publication/361596281_The_Anatomy_of_Price_Gouging_A_Regulatory_or_Competition_Law_Antidote/links/64eb0ff640289f7a0fbc28e5/The-Anatomy-of-Price-Gouging-A-Regulatory-or-Competition-Law-Antidote.pdf
8. Х.Норовсүрэн, “Цар тахлын үеийн Өрсөлдөөний эрх зүйд аж ахуйн нэгжийн ашиг сонирхлыг хамгаалах асуудал” 2021 он, хуудас 45 https://legaldata.mn/buteel/pdf?id=1238
9. Act on Emergency Measures for Stabilizing Living Conditions of the Public (Act No. 121 of December 22, 1973) https://laws.e-gov.go.jp/law/348AC0000000121
10. Attorney General James Stops Three Amazon Sellers From Price Gouging Hand Sanitizer and Recoups Funds For New Yorkers https://ag.ny.gov/press-release/2020/attorney-general-james-stops-three-amazon-sellers-price-gouging-hand-sanitizer 2025 оны 2 сарын 5-ны өдрийн хандалтаар
11. Anti-price-gouging law is neither good nor bad in itself: a proposal of narrative numeric method for transdisciplinary social discourses https://www.nature.com/articles/s44304-024-00005-y 2025 оны 2 сарын 5-ны өдрийн хандалтаар
12. Exploitative Pricing in the Time of Coronavirus—The Response of EU Competition Law and the Prospect of Price Regulation – PM https://pmc.ncbi.nlm.nih.gov/articles/PMC7454713/#sec9 2025 оны 2 сарын 6-ны өдрийн хандалтаар
13. The Alaska State Legislature Enrolled SB 241 https://www.akleg.gov/basis/Bill/Text/31?Hsid=SB0241Z 2025 оны 2 сарын 6-ны өдрийн хандалтаар

14. Consumer Life Accident Information https://www.jikojoho.caa.go.jp/ai-national/ 2025 оны 2 сарын 6-ны өдрийн хандалтаар